



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 10 өдөр

Дугаар

№1687.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1. Сумын төвийн төмөр бетон гүүр /Ховд, Буянт сум/ ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------|-----------------|---|
| Комиссын дарга: | Н.Ганзориг | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Ш.Даваатогтох | - Буянт сумын Засаг даргын Тамгын газрын дарга |
| | И.Гантогтох | - Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч |
| | Б.Ганзориг | - Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагч |
| | Д.Эрдэнэзаяа | - Буянт сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч |
| | Э.Амарбаясгалан | - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн |
| | Б.Сонинтуяа | - Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн |

С.Батдорж

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Архивын тасгийн дарга

Нарийн бичгийн


дарга: Ц.Сувдаа

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Сумын төвийн төмөр бетон гүүр /Ховд, Буянт сум/ ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ